

Хүн, хажуугаас асууж
„Алтан дэлхий дээр цаг ч гэсэн
Амьдаръя гэж хүсэх үү гэвэл
„Аль вэ, наад олсоо та нар
Ав, муу хар дайснуудаа“ гэж,
Ам дүүрэн хариулна би.
Ахуй чадлаараа хашгарна би.
Амьдралын төлөө яахаасаа ч,
Айж шантрахгүй би.
Анхны сорилтын машинаар,
Агаар тэнгэрт гарсан ч бэлэн.
Тэсрэх пуужин руу ганцаараа,
Тэр чиигээрээ орсон ч бэлэн,
Холын, гаригийг эрээд,
Хоног алдахгүй суусан ч бэлэн!

Цэлмэг тэнгэрийн
Цэнхэр өнгийг
Цэх харж явахдаа,
Амьдралын баярыг
Цээж дүүрэн
Агуулж, хадгалж явахдаа,
Ямар ч л гэсэн, энх тунх,
Яалаа ч л гэсэн, эрүүл саруул,